



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мандалговь хот

2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Д.Должинсүрэн

Утас: 70593113

Цахим хаяг: [Doljinsuren@audit.gov.mn](mailto:Doljinsuren@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.3 Албан шаардлага.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.Аудитын санал дүгнэлт



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 32

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АДААЦАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ДАВААЖАРГАЛ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012029747

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>167,212,471.20</b>	<b>115,421,953.10</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>39,525,567.00</b>	<b>4,235,654.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	39,913.00	0.00
33102	НДШ-ийн авлага	39,913.00	0.00
33500	Бусад авлага	39,485,654.00	4,235,654.00
33510	Байгууллагаас авах авлага	35,250,000.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,235,654.00	4,235,654.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>127,686,904.20</b>	<b>111,186,299.10</b>
35100	Түүхий эд материал	51,125,170.02	50,949,630.42
35110	Тусгай зориулалттай материал	51,100,670.02	50,484,280.42
35130	Эм боох материал	24,500.00	465,350.00
35400	Хангамжийн материал	76,561,734.18	60,236,668.68
35410	Бичиг хэргийн материал	2,017,870.00	1,771,119.00
35420	Аж ахуйн материал	32,821,929.68	27,987,459.68
35450	Барилгын засварын материал	15,161,000.00	4,653,000.00
35460	Хүнсний материал	30,100.00	8,007,290.00
35470	Бусад хангамжийн материал	25,691,834.50	17,262,800.00
35600	Мал амьтад	839,000.00	555,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>939,648,500.82</b>	<b>1,144,147,208.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>939,648,500.82</b>	<b>1,144,147,208.44</b>
39200	Биет хөрөнгө	902,126,500.82	1,106,625,208.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	862,140,599.68	1,081,611,692.68
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(101,833,196.07)	(152,172,065.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,300,000.00	15,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(15,300,000.00)	(15,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	112,454,755.49	133,283,516.49
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(28,684,189.02)	(34,187,471.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,365,827.44	89,882,059.44
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(24,027,104.10)	(31,879,158.62)
39217	Номын фонд	17,709,807.40	20,086,635.72
39300	Биет бус хөрөнгө	37,522,000.00	37,522,000.00
39301	Програм хангамж	1,192,500.00	1,192,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(1,192,500.00)	(1,192,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,522,000.00	37,522,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,106,860,972.02</b>	<b>1,259,569,161.54</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,106,860,972.02</b>	<b>1,259,569,161.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,106,860,972.02</b>	<b>1,259,569,161.54</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	897,971,845.05	897,971,845.05
51200	Хуримтлагдсан үр дүн	(425,070,089.08)	(272,361,899.56)
51210	Өмнөх үеийн үр дүн	(425,070,089.08)	(425,070,089.08)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	152,708,189.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	633,959,216.05	633,959,216.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,106,860,972.02</b>	<b>1,259,569,161.54</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>516,965,961.91</b>	<b>1,066,951,824.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,551,061.91</b>	<b>246,961,855.41</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	2,551,061.91	246,961,855.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	20,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	0.00	20,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	245,836,655.41
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	2,551,061.91	1,105,200.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>514,414,900.00</b>	<b>819,989,969.00</b>
1310	Улсын төсвөөс	442,190,100.00	703,064,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,190,100.00	703,064,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,248,900.00	8,428,469.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	0.00	8,428,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,248,900.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,975,900.00	108,497,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,975,900.00	108,497,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>457,479,557.45</b>	<b>908,741,537.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>457,479,557.45</b>	<b>908,741,537.35</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,852,657.45	873,265,955.02
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	312,476,410.00	535,781,369.00
210101	Үндсэн цалин	167,400,126.00	381,911,219.00
210102	Нэмэгдэл	124,309,293.00	109,850,077.00
210104	Урамшуулал	20,766,991.00	44,020,073.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,014,927.00	69,778,119.00
210201	Тэтгэврийн даатгал	26,756,873.00	48,311,619.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,955,276.00	5,365,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,646,274.00	3,967,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	605,153.00	1,515,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,051,351.00	10,617,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,997,994.00	101,292,960.67
210301	Гэрэл, цахилгаан	1,118,849.00	2,809,160.67
210302	Түлш, халаалт	50,669,145.00	96,993,800.00
210303	Цэвэр, бохир ус	210,000.00	1,490,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,409,118.50	23,781,984.10
210401	Бичиг хэрэг	463,900.00	1,719,820.00
210402	Тээвэр, шатахуун	721,760.00	1,562,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,000.00	665,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,180.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	297,800.00	1,649,500.00
210408	Бараа материал актласны зардал	6,708,478.50	18,184,934.10
2105	Нормативт зардал	1,331,862.00	21,219,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,400.00	688,300.00
210502	Хоол, хүнс	1,260,462.00	20,531,472.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,820,900.00	14,996,500.00
210604	Урсгал засвар	3,820,900.00	14,996,500.00
2107	Томилолт, зочны зардал	354,000.00	550,000.00
210702	Дотоод албан томилолт	354,000.00	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	611,000.00	492,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	175,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,500.00	65,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	240,000.00
210807	Газрын төлбөр	0.00	12,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,836,445.95	105,372,750.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,436,545.00	6,200,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,787,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	37,399,900.95	96,385,450.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	626,900.00	35,475,582.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	626,900.00	17,473,628.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	626,900.00	17,173,628.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	1,555,039.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,555,039.33

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	16,446,915.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	16,446,915.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>59,486,404.46</b>	<b>158,210,287.06</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>5,502,097.54</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	0.00	5,502,097.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	5,502,097.54
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>59,486,404.46</b>	<b>152,708,189.52</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>897,971,845.05</b>	<b>633,959,216.05</b>	<b>(486,673,882.98)</b>	<b>1,045,257,178.12</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	(486,673,882.98)	1,045,257,178.12
9	Тайлант үеийн үр дүн			61,603,793.90	61,603,793.90
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	(425,070,089.08)	1,106,860,972.02
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>897,971,845.05</b>	<b>633,959,216.05</b>	<b>(425,070,089.08)</b>	<b>1,106,860,972.02</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	(425,070,089.08)	1,106,860,972.02
<b>19</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>			<b>152,708,189.52</b>	<b>152,708,189.52</b>
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>897,971,845.05</b>	<b>633,959,216.05</b>	<b>(272,361,899.56)</b>	<b>1,259,569,161.54</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>514,414,900.00</b>	<b>820,009,969.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>20,000.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого		20,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		20,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		20,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>514,414,900.00</b>	<b>819,989,969.00</b>
1310	Улсын төсвөөс	442,190,100.00	703,064,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,190,100.00	703,064,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,248,900.00	8,428,469.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х		8,428,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,248,900.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,975,900.00	108,497,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,975,900.00	108,497,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>408,534,374.00</b>	<b>794,710,369.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>408,534,374.00</b>	<b>794,710,369.00</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,149,174.00	753,873,364.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	311,903,410.00	535,781,369.00
210101	Үндсэн цалин	167,400,126.00	381,911,219.00
210102	Нэмэгдэл	123,736,293.00	109,850,077.00
210104	Урамшуулал	20,766,991.00	44,020,073.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,961,930.00	69,738,206.00
210201	Тэтгэврийн даатгал	26,703,876.00	48,271,706.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,955,276.00	5,365,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,646,274.00	3,967,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	605,153.00	1,515,800.00

Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	6,051,351.00	10,617,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,997,994.00	101,292,960.67
210301	Гэрэл, цахилгаан	1,118,849.00	2,809,160.67
210302	Түлш, халаалт	50,669,145.00	96,993,800.00
210303	Цэвэр, бохир ус	210,000.00	1,490,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,165,880.00	6,162,299.00
210401	Бичиг хэрэг	132,500.00	1,473,069.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,562,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,000.00	665,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,180.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	216,200.00	2,461,500.00
2105	Нормативт зардал	2,271,360.00	24,261,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,400.00	1,129,150.00
210502	Хоол, хүнс	2,166,960.00	23,132,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	416,600.00	5,649,500.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210604	Урсгал засвар	416,600.00	5,649,500.00
2107	Томилолт, зочны зардал		550,000.00
210702	Дотоод албан томилолт		550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000.00	492,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ		175,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		65,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		240,000.00
210807	Газрын төлбөр		12,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		9,945,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,800,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		4,145,340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,385,200.00	40,837,004.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,385,200.00	22,835,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,385,200.00	22,535,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		1,555,039.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,555,039.33
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,446,915.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		16,446,915.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>105,880,526.00</b>	<b>25,299,600.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>25,299,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>25,299,600.00</b>
223	БУСАД ХӨРӨНГӨ		25,299,600.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		25,299,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>		<b>(25,299,600.00)</b>
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>105,880,526.00</b>	
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>105,880,526.00</b>	

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	811,561,500.00	793,579,745.67
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	811,561,500.00	793,579,745.67
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	788,721,000.00	770,744,695.67
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	552,066,300.00	535,781,369.00
210101	Үндсэн цалин	395,376,500.00	381,911,219.00
210102	Нэмэгдэл	111,368,600.00	109,850,077.00
210104	Урамшуулал	45,321,200.00	44,020,073.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,821,400.00	69,738,206.00
210201	Тэтгэврийн даатгал	48,354,900.00	48,271,706.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,365,200.00	5,365,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,967,900.00	3,967,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,515,800.00	1,515,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,617,600.00	10,617,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	102,847,600.00	101,292,960.67
210301	Гэрэл, цахилгаан	4,363,800.00	2,809,160.67
210302	Түлш, халаалт	96,993,800.00	96,993,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,490,000.00	1,490,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,536,200.00	5,506,830.00
210401	Бичиг хэрэг	884,000.00	883,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,565,000.00	1,562,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	665,000.00	665,000.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,172,200.00	2,170,600.00
2105	<b>Нормативт зардал</b>	24,266,700.00	24,261,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,133,900.00	1,129,150.00
210502	Хоол, хүнс	23,132,800.00	23,132,040.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,676,700.00	24,676,300.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	19,026,800.00	19,026,800.00
210604	Урсгал засвар	5,649,900.00	5,649,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	550,000.00	550,000.00
210702	Дотоод албан томилолт	550,000.00	550,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	507,500.00	492,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	175,000.00	175,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	65,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	12,500.00	12,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,448,600.00	8,445,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.00	5,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,648,600.00	2,645,340.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	22,840,500.00	22,835,050.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	22,840,500.00	22,835,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,535,300.00	22,535,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	305,200.00	300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	108,497,500.00	106,942,460.67
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	108,497,500.00	106,942,460.67
122005	Орон нутгийн төсвөөс	108,497,500.00	106,942,460.67

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)</b>	<b>8,428,469.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,428,469.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,428,269.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,028,469.00</b>
210401	Бичиг хэрэг	589,569.00
210404	Ном, хэвлэл	148,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	290,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,899,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,899,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,500,000.00</b>
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200.00</b>

2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>200.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>8,428,469.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>8,428,469.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,428,469.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	8,428,469.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Сурагчдыг бие даан бүтээлчээр сурах, хөгжих, хүмүүжих сургалтын таатай орчинг бүрдүүлэн ёс суртахууны боловсролд суурилсан харилцааны соёлтой, хариуцлагатай, “Зөв монгол хүн” болгон төлөвшүүлэх явдал юм” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв

толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 908,741.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,087.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,361.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 152,708.2 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн бус хөрөнгийн данс бөгөөд үндсэн хөрөнгөнд их засвар хийж, сайжруулалтаар бүртгэсэн нь дүнд нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	167,212.5	115,422.0	(51,790.5)
<b>АВЛАГА</b>	39,525.6	4,235.7	(35,289.9)
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	127,686.9	111,186.3	(16,500.6)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	939,648.5	1,144,147.2	204,498.7
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	939,648.5	1,144,147.2	204,498.7
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,106,861.0	1,259,569.2	152,708.2
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,106,861.0	1,259,569.2	152,708.2
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,106,861.0	1,259,569.2	152,708.2
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,106,861.0	1,259,569.2	152,708.2

Бараа материал дансны үлдэгдэл 111,186.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 16,500.6 мянган төгрөгөөр буурсан нь жилийн эцсээр хангамжийн материалын дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийг цэгцлэн, ашиглалтгүй болсон бараа материалуудыг акталж, устгалд оруулсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 24,926.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 373.0 мянган төгрөгийн ном худалдан авч, 226,214.9 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж 54,871.7 мянган төгрөгөөр бүртгэлд авсан байна. Мөн 38,193.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлан, данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,259,569.2 мянган төгрөг болж 152,708.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 844,176.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 844,176.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 32,615.0 мянган төгрөгөөр бууруулан 811,561.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн бууралт нь цар тахлын үед хичээл орохгүйтэй холбоотой хоолны зардлыг бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 811,561.5 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 811,561.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 97.7 хувийг зарцуулж, нийт 17,981.7 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 793,579.7 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаар дамжин “Хүүхдэд ээлтэй ертөнц төсөл”-ийн үлдэгдэл 8,428.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс төслийн үйл ажиллагааны зардалд 8,428.3 мянган төгрөгийг зарцуулж, 0.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дулааны эрчим хүчний үйлчилгээг “Ирмүүн түшиг” ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м<sup>3</sup> тутамд 1500 төгрөг боловч гэрээнд өөрчлөлт оруулалгүй хуучин гэрээний үнээр 96,993.7 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар болсон.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,060,263.2 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож, хэрэгжилт 94 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,800.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,235.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 4,235.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 4,235.6 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Аудитаар санхүүгийн тайлан дахь 4,235.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.
2. Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

Д / Д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1											
	Дүн										
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	Аудитаар санхүүгийн тайлан дахь хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1						1	4,235.6		
2	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн	1						1			
	Дүн	2						1	4,235.6	0	0
	Нийт дүн	2	4,235.6					1	4,235.6	0	0